

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Д.Тэмүүлэн

Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа

Товч танилцуулга: Төрийн тусгай хамгаалалтын газар нь Хүннү гүрний үе, Их Монгол Улс, Богд Хаант Монгол Улс, Ардын Засгийн газар, Шинэ үеийн Төрийн тусгай хамгаалалтын газар, Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газар гэж үе шат дараатайгаар үүсэж хөгжиж ирсэн түүхтэй. Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн чиг үүрэг нь Хамгаалуулагчийн аюулгүй байдал болон Төрийн Ордон, Засгийн газрын байруудын аюулгүй байдал хамгаалалтыг иж бүрэн тасралтгүйгээр найдвартай хангах үйл ажиллагааг нэр төртэйгээр гүйцэтгэж ирсэн 86 жилийн түүхтэй байгууллага юм.

Түлхүүр үг: Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Төрийн Тусгай хамгаалалтын газар, Дотоодыг хамгаалах газар, Дотоод явдалын яам, Нийгмийг аюулаас хамгаалах газар

Хүннү гүрний үеийн төрийн тусгай хамгаалалтын тухай Монгол Улсын нутагт хамгийн анх төрт улсаа байгуулсан Хүннү нар өөрсдийн хот хэрмийг цогцлоож түүнийхээ дотор орд өргөө, цайз хэрмээ байгуулж байжээ. Монгол Улсын нутгаас Хүннүгийн үед хамаарах 15 хэрэм хот олдоод байна. Хүннү гүрний үеийн хэрэм нь дөрвөлжин зохиомжтой дөрвөн талдаа хоёр давхар сүрлэг өндөр вааран дээвэртэй хаалгатай ба нэг үүдтэй аж.¹

Ихэнхдээ өмнө зүг харсан хаалга нь элэгдэл ихтэй байх нь ажиглагддаг. Шороон хэрэм нь гадуураа сувагтай байгаа нь хамгаалалтын арга дөнгөж боловсорч байсныг харж болохоор байна. Түүнчлэн төрийн тусгай хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг хамгаалагчийн албан тушаалыг “Хань улсын бичиг” 94 дэвтэрт бичсэнээр Шаньюйн хамгаалагч нарыг баруун, зүүн дагагсад хэмээн тэмдэглэсэн байдаг.

¹ Монгол- Солонгосын хамтарсан төслийн багийн судалгаа 2013-2016 он



Зураг.1 Хүннү гүрний үеийн хотын үлдэгдэл буюу Гуа дов нь Төв аймгийн Баянжаргал сумын нутагт оршидог. (Хүннүгийн язгуурын зуны орд

Хүннүгийн хааны орд өргөөг хамгаалахад хойд, өмнөд, баруун, зүүн хаалга тус бүрт харуул зогсох бололцоотой. Мөн өрнийн хэрмийн төв хэсэгт барьсан барилгаас 100-150 метрийн зайд тусдаа барьсан дөрвөлжин зохиомжтой барилга нь тухайн үеийн Хүннүгийн харуулууд хэрмийнхээ дотор талд байрлаж байсныг харуулж болох юм. Харин дорнын зохион байгуулалттай хэрмүүд нь хэрмийнхээ дотор талаар хүн явах замтай бөгөөд энэ нь ордныг тойрч эргэх ээлжийн харуул хийх боломжийг бүрдүүлж байна. Хүннү гүрний дараа үеийн хотын дурсгал Сяньби, Жужаны үеийн хот хэрэм одоогоор Монгол Улсын нутгаас олдоогүй байна. Харин Түрэг, Уйгарын үед холбогдох хот суурин хэд хэд олдоод байна. Хүннү гүрний үеэс эхэлсэн хаад ноёдын орд өргөөг барихдаа тэднийг хамгаалах асуудлыг давхар бодолцож байжээ. Энэ нь Уйгурын хаант улсын үед илүү төгөлдөржиж өндөр бат бэх цайз хэрэм, олон давхар хана хэрэм бүхий хамгаалалтын тогтолцоог бий болгосон байна. Нэг талаар энэ нь хаан, түүний гэр бүл, язгууртнууд, худалдаачдыг хамгаалах зориулалттай боловч

ихэвчлэн улсын аюулгүй байдлыг хамгаалахтай шууд холбогдож байжээ. Түрэгийн үед байсан нүүдэлчдийн гэр хэлбэртэй орд өргөөг хамгаалахад хэрэглэгдэж байсан зохион байгуулалт нь суурьшил бий болж хүн ам нягтаршсантай холбоотойгоор хаадын орд өргөөг улам нарийн зохион байгуулалттай хамгаалах шаардлага тулгарсан байна. Хотын хамгаалалт, хот доторх ордны хамгаалалт, хааны амь насыг хамгаалах амь сахигч зэрэг нь түүхэн цаг хугацааны шалгуураар бий болсон юм.

Уйгурын дараа байгуулагдсан Хятан улсын үед нэгэнт эрчээ аван хөгжсөн нүүдэлчдийн хаад язгууртны хамгаалалтын тогтолцоо хамгаалалтын олон төрөл зүйл болж хуваагдсан бөгөөд тус тусын үүрэг зориулалт бүхий яамдыг бий болгосон байдаг. Монголын төрийн хамгаалалт нь Уйгурын Хаант Улсын үед цогцоор бүрэлдэн бий болж Хятан гүрний үед уламжлан хөгжсөн хамгаалалтын тогтолцоо Монголын их гүрний хаадын хамгаалалтын үндэс суурь болжээ.

Их Монгол Улсын үеийн төрийн тусгай хамгаалалтын тухай:

Монголын нууц товчоонд төрийн тусгай хамгаалалттай холбоотой Их Монгол Улсын үед

Турхаг, Хэвтүүл, Хишигтэн, Хор асгагч (Нум сумтан), Илд асгагч (Сэлэмтэн)-ийн тухай цөөнгүй тэмдэглэсэн байдаг.



Зураг.2 Төрийн түүхийн музей Их хуралдайн зураг
(Энэ зурагнаас тухайн үеийн хамгаалалтыг харж болно)

Чингис Хаан Наймантай байлдахаар 1204 оны хавар мордохын өмнө цэргээ аравтын тогтолцоонд оруулж, уламжлалт турхаг цэрэгт үндэслэсэн хишигтэн цэргийг байгуулж мянгат, зуут, аравтын захирагчид, урт дурын /чөлөөт/ иргэдийн хөвүүд дүү нараас сонгон авч 80 хэвтүүл, 70 торгууд томилов¹. Хишигтэн цэргийг бүтээсэн нь Их Монгол Улсын улс төр, цэрэг-засаг захиргааны аюулгүй байдлын үндэс болсон юм. Түүнчлэн Чингис Хаан 1206 онд Их Монгол Улсыг байгуулснаар төрийн хамгаалалтын үйл ажиллагаа улам нарийсч, хишигтний зохион байгуулалт, дэг журам улам чангарч эрх, үүрэг нь үлэмж нэмэгдсэн байна.

Тулгар төр байгуулсны дараа Чингис Хаан "...Урьд би 80 хэвтүүл манаачтай, 70 шадар хишигтэнтэй байв. Одоо мөнх тэнгэрийн өршөөлөөр, тэнгэр газрын ивээлээр хүч аугаа нэмэгдэж гүр их улсыг хамтатган нэг жолоонд оруулсан тул одоо надад 1000 шадар хишигтэнг ялгаж өг. Хэвтүүл, хорчин, торгуудын хамт түмэн хүн /10 000/ болгож өгтүгэй..." гэж зарлиглаж, хишигтэнг хэрхэн бүрдүүлэх талаар "... Миний хишигтнийг томилоход түмт, мянгат, зуут, арваны ноёдын хөвүүд сул хүний /урт дурын буюу чөлөөт иргэд/ хөвүүдийн дотроос миний дэргэд тэнцэх бэлгэ эрдэмтэй, бие сайтайгий нь ялгаж оруултугай." Гэж зарлиг болгосон байдаг.² Илдтэн хаантай хамгийн ойр, түүний гадуур торгууд,

¹ Монголын нууц товчоо, Ш.Чоймоо, УБ, 2006 он, тал 132.


² Монголын нууц товчоо, Ш.Чоймоо, УБ, 2006 он, тал 172.

гадуур нь хорчид байрлаж явдаг нь тэдний зэвсгийн хөнөөх чадвартай холбоотой гэж үзэж болох

бөгөөд хэвтүүлд хамгийн өндөр эрх мэдэл үүрэг, хариуцлагыг ноогдуулж байжээ.

Аян дайнд Чингис хаан өөрөө оролцвол их цэргийн байлдааны журмын их гол нь түүний “Хишигтэн” юм. Монгол цэргийн түүхэн товчоон номонд Нууц товчоог үндэслэн “...Чингис Хааны зарлигаар чандлан

тогтоосон хишигтэн цэргийн аяны журмыг авч үзвэл: Хааны орд гэрийн өмнө Архай Хасарын Өтгөс баатруудын мянгат манлай болж, ич, солгой этгээдэд болон ар талыг бусад хэвтүүл, хорчин торгон цэрэг мянгат, мянгатаар баг болон хэдэн давхар халхлан явдаг байжээ.



Зураг.3 Хишигтэн цэргийн аяны журам
(Монгол төрийн түүхийн музей)

Хишэгтэн гэдгийн утгыг нягтлахад монгол, түрэг хэлний аль алинд “Ээлж” гэсэн санааг илэрхийлж байгаагаас ¹ үзвэл “хишэгтэн” нь ээлжтэн гэсэн үг юм. Монголчууд эдүгээ мал хариуцах ээлж тохиосныгоо “хишиг өдөр”, “хонины хишигтэй” хэмээн хэлсээр байгаа билээ. Харин ээлжээр харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж хэвтүүл, хорчин, турхаг, баатад буюу баатруудыг нийтэд нь “хишигтэн” буюу “ээлжтэн” хэмээн нэрлэсэн байна. Түүнчлэн хишигтэн

цэргийн онцлог, үйл ажиллагааны журам, ээлж солилцох заавар, цуваа үйлдэх үед хамгаалах журам, зэвсэг хэрэглэх талаар ч маш нарийн заасан нь “Орчин үеийн хамгаалалтын үйл ажиллагаа”-ны үндэс зарчимд нийцэж байгаа юм. Хишигтэн цэргийн харуулд гарах журам нь Чингис хаан зарлиг болруун Хорчин, Турхаг, Хишигтэн, Буурч, Агтач, үүдэч өдөр хишиг орж нар шингэхийн алдад хэвтүүлд зайлж, агтастаа гаран хонотугай. Хэвтүүл шөнө гэр орчин, хэвтэхүүнээ хэвтүүлж,

¹ Монгол хэлний товч тайлбар толь, Я.Цэвэл, УБ, 1996 он.

үүдэнд байхыг хишиглэн байгуултугай. ...Гурван шөнө, гурван өдөр хишиг өдрөө дуусч мөнхүү ёсоор гурван шөнө хонодож, егүүтгэлдэж шөнө хэвтүүл айтугай, орчин хэвтэж хонотугай хэмээн зарлиг болгосон байдаг. Байлдааны журам болон цуваа үйлдэхэд хамгаалах заавар нь цэргийн цуваа алс хол аялан явах үед, нэг талаар дайсны гэнэтийн довтолгооноос цувааг, батлан хамгаалах, нөгөөтэйгүүр өөрийн цэргийн хөдөлгөөнийг дайсан этгээдэд мэдэгдэхгүй байх, аюул учрахад хохирол бага амсах, цаашилбал цувааг түргэн, шуурхай аялуулах дайсантай тулгарсан тохиолдолд аяны байдлаас байлдааны байдалд төвөггүй, хялбар маневр хийн шилжих шаардлагатай байдаг. Их Монгол Улсын цэргийн аяны журмыг авч үзвэл алгинч, манлай, гол хүч, аяны хамгаалалт¹ гэсэн 4 цуваанаас бүрдэх бөгөөд тус тусдаа хувийн зохион байгуулалттай, үүрэгтэй байжээ.



Зураг.4 Богд хааны Амарбаясгалант, Эрдэнэ зуу хийд орох, Долоон хошуу даншиг наадам үзэх, хаан ширээнд залах зэрэгт жуузанд залж төрийн ёслолын үеийн шадар цэргийн хамгаалалтын зураг

Хишигтэн нь эзэн хааны зарлиг ёсоор онцгой эрх эдлэн эзэн хааны амь бие, орд өргөөг хамгаалж, түүнд орох, гарах, хүмүүсийн асуудлыг эрхлэн хариуцаж, зэр зэвсэг, эд агуурс, хоол ундны бүхий л асуудлыг эрхлэн хариуцаж, ав шувуу, орд өргөөний нүүдэл суудал, нутаг ус шилж сонгох ажлыг гүйцэтгэж, дайн байлдааны үед гол цэрэг нь болж түрүүлэн ордог байнгын армийн шинжтэй байсан аж

Богд Хаант Монгол Улсын төрийн тусгай хамгаалалтын тухай

1911 оны 12 сарын 29-ний өдөр Монголчууд Манжийн эрхшээлээс гарч, тусгаар Монгол Улсыг байгуулан улсын нэрийг МОНГОЛ, оны цолыг олноо өргөгдсөн гэж нэрийлэн 8 дугаар Богд Жавзандамбыг “Шашин Төрийг Хослон Баригч, Наран гэрэлт, Түмэн наст, Богд Хаан”-д өргөмжлөн түүний эрх ямбыг нэмэгдүүлэн, шадар цэрэгтэй болгосон байна.

¹ Чингэс хааны цэргийн тухай өгүүлэл, Ж.Базарсүрэн, УБ, 2006 он.



Ногоон ордон (Зүүн хэсэгт Богдын шадар цэргийн байр тэдний бэлтгэл сургуулилтыг харуулжээ

(Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей)

Богд хааныг хаан ширээнд залах үеийн хамгаалалт нь олон шадар цэрэг замын хоёр талаар буу зэвсэгтэй, ёслолын хувцастай жагсаж байжээ. Богд хааны шадар цэргийн захирагч Тогтох тайж бол Өвөр Монголын Жирэмийн чуулганы Өмнөд Горлос хошууны нутаг хойд этгээдэд Хар мөрөн голын баруун эрэг дэх Таван таг-Гурван гэр хэмээх газар хохь тайж Энхбилэгтийн гэр бүлд 1863 онд харагчин гахай жилд төрсөн, Хиад аймгийн боржигон овогтон¹. 1911 оны цагаагчин гахай жилийн Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний дараахан И.Я.Коростовец, И.Ломакина, Э.Тогтох нарыг Эрхүү мужийн амбан захирагчийн газраас дуудан аваачиж, Монголын шинэ байгуулсан засгийн, (Хүрээний бүх хэргийг түр шийтгэх газар буюу түр засгийн газар) хэрэгт туслалцуулахаар явуулсан байдаг. Богд гэгээн тайж Э.Тогтохыг хүрээнд ирэх үед түүнд дотночилон хандаж, түүнийг

өөрийн бие хамгаалах шадар цэргийн дарга болгосон юм.

Дээд сүмийг хариуцсан даамал тахилч, нярав, зоогийн яам, идээч, өргөөч нар бол Богд хааны шадар албаны хүмүүс байсан бөгөөд тэрчлэн сангийн лам нар, сангийн дарга нар, харчууд нь тус тус мал, амьтан болон аж ахуйн бэлтгэлүүдийг хийдэг хүмүүс байсан. Дээд сүм дээр бас торгон цэргийн албан байгууллага байсан бөгөөд Богд хааны бие хамгаалагч монгол цэргүүдийг Богдын шадар цэрэг буюу “торгон” цэрэг гэж нэрлэдэг байсан. Тэд хуульчилсан хувцастай, дөрвөн тал саравчтай төв малгай өмсдөг бөгөөд сэлэм зүүсэн тав гээгтэй харчууд байдаг байв.

Цэргийн яамнаас “Дээд сүмийн ойр газар тусгайлан суулгасан түшмэл цэргүүдийн дагаж явах дүрэм”-ийг боловсруулан олноо өргөгдсөний 3-р оны цагаан сарын 26-нд дагаж мөрдүүлэхээр зарлан тушаажээ.

¹ Төрийн тусгай хамгаалалтын тухай, УБ, 2018 он.

Богдын өвлийн ордны дэргэд суулгасан цэрэг нь нэгт Богд хааны орд өргөөг сахин хамгаалах, хоёрт Богд Эзэн, Улсын эх дагиныг Өвлийн ордноос төрийн шар ордонд залрах зэрэгт тушаалаар жагсан ёслох үүрэгтэй байжээ.

Тус дүрэм нь нийт долоон хэсэгтэй бөгөөд төрийн ёслол, хамгаалалттай холбогдсон анхны хууль эрх зүйн баримт бичиг мөн. Уг дүрэмд:

1. Өдөр бүр зэвсэгтэй, морьтой цэрэг гурав, явган цэрэг гурав, шөнө тутам морьтой ба явган тус бүр арвыг томилон гаргаж, Богд хааны ордны дотуур, гадуур цаг ямагт цагдан сэргийлж, гаднаас ирэх хүмүүсийг байцаан монгол хүн болбоос явуулж, гадаадын хүн болбоос зохих газар мэдэгдэн хэрхэхийг шийдвэрлэх;

2. Шөнө тутам аравны даргаас нэгэн хүнийг томилон гаргаж, хааны ордны манаанд гарсан цэргүүдийг бүртгэн шалгах;

3. Богд хаан, Эх дагиныг залрахад дээрээс тушаагаагүй болбоос түшмэл цэргүүд үл жагсах бөгөөд тушаалаар жагсаж, бараа болсон үед жагсаалаас гарч Богдод мөргөх, дуу чимээ гаргахыг хориглох;

4. Ерөнхийлөн захирах түшмэл нь харьяат цэргүүдийг өглөө, үдэш бүртгэн тоолж байх, цэргүүд гадагш явах тухайд эхлээд аравны даргад мэдэгдэж, аравны дарга нь ерөнхийлөн захирах даргад чөлөө авч байх, мөн

өдөр бүр арван цэрэг томилон бүх цэргийн хүнс зүйлийг авахуулж байх;

5. Цэргийн байрлах гэрт жинхэнэ албаны бус энгийн хүмүүсийг ирүүлэх, оруулах, худалдаа наймаа хийх, үймж самуурах зэргийг хориглох;

6. Харьат цэргүүд ямарваа нэгэн хэрэг будлиан өдүүлсэн эсэхийг сар бүрий шинийн 1, 15-нд тогтмол цэргийн яаманд мэдүүлж байх;

7. Агт морьдыг сайтар арчлан тордож байх зэрэг заалт орсон байна.

Энэхүү дүрмэнд ихэвчлэн хориглох заалт орсон байх бөгөөд тэдгээрийг зөрчсөн түшмэл, цэргийг “Хүнд шийтгэх” тухай заалт оржээ. Дүрмийн агуулгаас үзэхэд Богд хааны ордныг хамгаалах цэрэг нь аравтын зохион байгуулалттай байсан бөгөөд тооны хувьд төдий л олон биш юм. Энэ дүрэм нь Монгол Төрийн ордны харуул хамгаалалтын тухай хууль эрх зүйн түүхэн уламжлалд онцгой байр суурь эзлэнэ.

Ардын засгийн газрын төрийн тусгай хамгаалалтын тухай:

Шинээр байгуулагдсан Дотоодыг хамгаалах газрын дүрмэнд “...Дотоодыг Хамгаалах Газрын эрхлэн гүйцэтгэх зүйлүүд гурав дугаар зүйл, зургаад Ардын засгийн эрх баригчид ба нам, эвлэлийн гишүүдийг санаатайгаар амин аюул хорлолд хүргэх явдал... зэргийг цаг үргэлжид чангалан сэргийлбэл зохимой...” гэснээр үзэхэд хамгаалалт аюулгүй байдлын асуудлыг онцгойлон үзэж байсан байна.



Зураг.7 Э.Рэнчию, С.Данзан, Д.Сүхбаатар, А.Данзан, Шумяцкий, Бодоо болон ардын намын удирдагчид жанжныг хамгаалах цэргүүдийн хамт

Алтанбулагт Сүхбаатарын хөшөө байгаа хашаанд 1921 оны 03 сард 2 жижиг байшин байсан бөгөөд нэг жижиг нь байшинд цэргийн удирдах тушаалын хүмүүсийг суулгаж, хашаанд барьсан гэрт Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нар сууж байжээ. Д.Сүхбаатарын бие хамгаалах 10 цэргийн даргаар Загдыг 1923 оны 03-р сарын 18-ны өдөр Хиагтыг эзлэхээр дайрахын өмнө томилсон байдаг. Д.Сүхбаатарыг Бүх цэргийн жанжинаар томилсон бөгөөд дайны үед улсыг удирдах үүргийг гүйцэтгэх тул түүнийг байнга хамгаалах үүргийг өгсөн байна. Бие хамгаалах цэргийн үүрэг нь туг манах, Харуул манаа, Зарлага гэх зэрэг үүрэгтэй байсан байна¹.

Зөвлөлт улсад гэрээ байгуулахаар 1921 оны 09 сард жанжин Д.Сүхбаатар, Данзан, гүн Цэрэндорж, жонон ван Ширнэндамдин, бичээч Будын Даваа, хэлмэрч Эрдэнэбатхаан нарын хамт

явсан. Жанжны хамгаалагчаар их буугийн дарга байсан барга Өлзий, Мягмар нар явсан байдаг. Д.Сүхбаатар хувьсгалын дараа Линентэй очиж уулзахдаа Дзержинский, Чичерин, Луначерский, Фрунзе нартай бас уулзсан бөгөөд олон хүнтэй уулзсан гэж бусдад битгий хэлээрэй хэмээн Мягмарт захиж байжээ.

Түүнчлэн жанжин Д.Сүхбаатарын гэр, хашааг хамгаалж шөнийн цагт Хүдэр, шар Батаа, Осор, Д.Олзот нар ээлжлэн харуул манаа хийдэг байсан аж. Нэгэн шөнө хашааг нэг хүн давж ирснийг баривчлан шалгахад гар буугаар зэвсэглэсэн түвд хүн байсныг улсын цагдан сэргийлэхэд хүргүүлсэн байдаг. Жанжны хамгаалалгч нар түүнийг өдөр бүр ээлжлэн дагаж явдаг, шөнийн манаанд гарах, жанжны болон өөрсдийн морийг мал маллах ажил хийдэг байсан.

¹ Төрийн тусгай хамгаалалтын түүхэн замнал I УБ 2014 он.

Төрийн тусгай хамгаалалтын түүхэн замнал II УБ 2014 он.

Дотоодыг хамгаалах газрыг 1922 оны 07 сарын 16-ны өдөр анх байгуулахад энэ газрын бүрэлдэхүүнд харуул хамгаалалтын үүргийг дагнан гүйцэтгэх зорилготой цөөн хүний тасгийг байгуулж, бие бүрэлдэхүүнийг Ардын журамт цэргийн 1 дүгээр морин хорооноос 13 цэргийг сонгон авч бүрдүүлжээ.

Тухайн үед бүх цэргийн Зөвлөлтийн Газраас Цагаан орос ялт Мячиков, Бороина нар Монголын ардын засгийг унагаахыг хичээж, жанжин Д.Сүхбаатарыг алж, үхэр бууг эвдэх хэргийг Дотоодыг хамгаалах газар шалгаж, Цэргийн Зөвлөлтийн Газраас хэлэлцээд харьяат ялт 2 хүнийг цаазаар авсан байдаг. Харин хашаа давж орж ирсэн гэх буутай түвд хүний талаарх мэдээ олдоогүй байна.

Дотоодыг хамгаалах газрын тусгай салаанд байсан халимаг цэргүүд энгийн хувцастайгаар Намын их хурлын болон төлөөлөгчдийн хамгаалалтад ажиллаж байсан бөгөөд 1928 оны Намын хурлаас хойш Дотоодыг хамгаалахын Тусгай салаанд байсан халимаг цэргүүдийг буцаан татсан байна. Мөн засгийн газрын байр хамгаалалттай байсан төдийгүй комендартгаар орос хүн ажиллаж байсан байна.

Цагдан сэргийлэх газрыг Дотоодыг Хамгаалах Газрын мэдэлд шилжүүлж 1932 оны 02 сарын 23-нд тус газрын даргын 66 дугаар тушаалаар Цэргийн бөгөөд хязгаарын хэлтэст захируулснаар харуул хамгаалалтын

асуудлыг тус хэлтэс, гүйцэтгэх ажил, хамгаалалтыг Нууц улс төрийн хэлтэс эрхлэх болсон байна. ДХГ-ын Нууц улс төрийн хэлтэс нь нам, засгийн удирдагчдын аюулгүй байдлыг хангах үүргийг бусад нэгжүүдтэйгээ хавсран гүйцэтгэж байжээ.

БНМАУ-д Японы түрэмгийлэгчид халдан довтлох бэлтгэл ажлаа идэвхжүүлсэн учир ДХГ-ын орлогч дарга Ц.Гиваапил “Байлдааны үед засгийн газрыг хамгаалах төлөвлөгөө” боловсруулсныг 1935 оны 12 сард ДХГ-ын дайчилгааны комиссын анхдугаар хурлаар зөвшөөрч улмаар “БНМАУ-ын нам, засгийн удирдагч нарыг хамгаалах тухай төлөвлөгөө”-г Нууц улс төрийн хэлтэс боловсруулсан байна. Түүнд нам, төрийн удирдагчдын хамгаалалт байнгын бус байгааг онцлоод Улсын Бага хурлын дарга А.Амар, Ерөнхий сайд П.Гэндэн, Ерөнхий сайдын орлогч сайд Х.Чойбалсан, Т.Дэмид, Намын төв хорооны нарийн бичгийн дарга Б.Элдэв-Очир, Д.Лувсаншарав, Лувсандорж, тэргүүлэгч гишүүн Д.Намсрай, Мэнд, Яндаг, О.Дашчирав нарыг хамгаалалтад авах, хамгаалалтыг... Нууц¹ улс төрийн хэлтэс голлон бусад хэлтсүүдээс оролцож явуулахаар тогтсон байна.

Мөн ДХГ-аас “... хамгаалан сэргийлэх явдлыг нарийн чанд болгохын тулд ДХГ-аас эрхлэн нам, эвлэлийн Төв хороод, Улсын хянан байцаахын дарга нар, Улсын бага хурлын дарга, Засгийн газрын Ерөнхий

¹ Тагнуулын операци тэргүүн дэвтэр, Л.Батдолгор, УБ 2015 он.

сайд, Цэргийн зөвлөлийн тэргүүлэгчид нам, Засгийн газрыг... ” цэргийн харуултай болгож тусгай хамгаалалтад оруулах санал төлөвлөснийг 1932 оны 03 сарын 28-нд Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нар 16-р хурлаас ёсоор болгожээ.

Шинэ үеийн төрийн тусгай хамгаалалтын тухай:

Улс хувьсаглын 16 жилийн ойн баярын өмнө 1937 оны 07 сард ДЯЯ-ны орлогч сайд бөгөөд Улсыг аюулаас хамгаалах газрын даргын шийдвэрээр тус яамны Эдийн засгын хэлтсийн ажилтан Ж.Намжил, Улс төрийн хэлтсийн ажилтан Майдар, Эсэргүүцэн тагнах хэлтсийн ажилтан Дэмбэрэлсүрэн нарт Маршал Х.Чойбалсангийн биеийг наадмын өдрүүдэд хамгаалах тушаал өгч гүйцэтгүүлээд дараа нь тэднийг бие хамгаалагчаар үргэлжлүүлэн томилон ажиллуулж, 1938 оны орон тоог баталсан ДЯЯ-ны сайдын 130 тоот тушаалаар тус яамны нэгдүгээр хэлтсийн хоёрдугаар тасгийн харъяанд бие хамгаалагчаар албан ёсоор томилсноор шинэ цагийн төрийн хамгаалалтын албаны эх суурь тавигджээ.

Намын Төв Хороо, Засгийн газрыг хамгаалах комендатурыг 1938

онд ахлах комендант 1, хянагч 2-ын орон тоотойгоор байгуулж нэвтрэх үнэмлэх олгох, шалгах үүрэг хүлээлгэжээ. Намын Төв Хороо ба Засгийн газрын жижүүрийн комендантын дагаж гүйцэтгэх зааврыг 1941 онд ДЯЯ-ны орлогч сайд батлан гаргажээ. Уг зааварт “Жижүүрийн комендант өглөө 9 цагаас 13 цагт хүртэл, орой 17 цагаас шөнө 24 цаг хүртэл ажиллана. Пропуск хянагчид 24 цагт ээлжээр, нэг нь 8 цагаар ажиллана.

ДЯЯ-ны I хэлтсийн 1 дүгээр тасаг ажлыг нь удирдаж байсан аж. Жижүүрийн комендантын үүрэг нь Пропуск хянагчдын ажлыг хянан шалгах, дарга нарын зөвшөөрлөөр пропуск бичиж олгох, ажлын дараа тасалгааг шалгаж үзэх, галын аюулаас хамгаалах зэргийг хариуцна. Ажлын тухай 1 дүгээр тасагт тайлагнана” гэжээ. Нам, засгийн удирдагч нарыг хамгаалах тухай шинэ зааврыг 1939 онд боловсруулан батлуулсан байна. Тухайн үед Маршалыг хамгаалах групп нь өөрийн мэдэлд ахлах

комиссар 2, жинхэнэ комиссар 4-тэй ажиллаж, байрны гадна талыг тусгай салаагаар хамгаалуулахаар дүрэмд заасан байна.



Зураг.8 Маршал Х.Чойбалсангийн хамгаалалтын зураг

Маршал Х.Чойбалсанг цэргийн ангиудаар явах үед Бьюик, М-1 суудлын авто машин хөлөглүүлэн, байлдааны хуягт машинаар дагаж, агаараас хамгаалж байсны дээр фронтын шугамд хөнгөн хуягт машинд суулган явуулж байжээ. Энэ нь байлдааны талбарт нам, засгийн тэргүүнийг үлэмж зэвсэг, техник, хэрэглэн хамгаалсан анхны том хамгаалалт байсан бөгөөд шинээр байгуулагдсан манай хамгаалалтын алба үүргээ сайн биелүүлсэн явдал юм. 1939 оны 07 сарын 25-нд тусгай группын дарга энхжүүлэгч Н.Шарав, орлогч дарга, хүмүүжүүлэгч М.Өлзийт, сургагч Ступин, туслах сургагч Басенко нарын 50 шахам хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан Халх голын байлдааны ажиллагааны үед ажиллуулсан бөгөөд дээрх ажилтнууд маршалын аюулгүй байдлыг хангах гол үүргийг тус тусын чиглэлээр зохион байгуулан оролцжээ.

ДЯЯ-ны сайдын 1940 оны 466 дугаар тушаалд “Монгол Улсын төрийн дээд эрхийг барих Улсын 8 дугаар их хурал 06 сарын 20-нд нээгдэн хуралдах тул нам, засгийн удирдагчид ба хурлыг хувьсгалын эсэргүү дайснуудын элдэв хор аюулаас хамгаалахын тулд их хурлыг эхэлсэн өдрөөс дуустал нь тусгай хамгаалах группыг зохион байгуулахыг 3 дугаар комиссар Осоржав, хамгаалах тасгийн дарга ахлах лейтенант Шархүү нарт даалгаж, хамгаалах группэд аюулаас хамгаалах газар, хэлтсүүдээс зохих тооны хүн

томилон зохион байгуулж, хамгаалалт хийхийг даалгасан юм.

Мөн 1940 онд хуралдсан МАХН-ын 10 дугаар их хурлын хамгаалалтад гүйцэтгэх хэлтсүүдээс 33 ажилтныг татан авч 15 хоног ажиллуулж, элдэв аюул осолгүйгээр өнгөрүүлсэн зэрэг нь тус албанаас зохион байгуулсан анхны томоохон хамгаалалтуудын нэг байсан.

Цаг үеийн нөхцөл байдлаас үндэслэн 1941 оны 06 сарын эцсээр хамгаалалтыг улам нягтруулж, сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор ДЯЯ-ны Одон тэмдэгт Тусгай хорооноос бага дэслэгч Доржсүрэн, Цэрэндорж даргатай 2 салаа цэргээр Намын төв хороо, Засгийн газар болон хамгаалах объектуудын өвөл, зуны байрыг хамгаалахаар шийдвэрлэж, цагдан сэргийлэхийн тусгай сумангийн хамгаалалтыг сольсон байна.

Маршал Х.Чойбалсан хасгийн дээрэмчдийн толгойлогчтой алс хязгаарт хээрийн нөхцөлд хийх уулзалтыг ДЯЯ-ны орлогч сайд хошууч генерал Б.Дорж, түүний зөвлөх П.П.Пахамов нараар ахлуулсан групп газар дээр нь тус яамны Гадаад тагнуулын газар, хилийн цэргийн 5 дугаар отряд, түүний тагнуулын тасаг, БаянӨлгий, Ховд аймаг дахь хэлтсүүдийн шугамаар холбогдох судалгааг маш нарийн хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авч, бүх бэлтгэлийг ханган хамгаалалтыг зохион байгуулжээ.

Ховд аймгийн Булган сумын нутаг Алаг толгой гэдэг газар маршал Х.Чойбалсангийн байрлах болон

уулзалтын гэрүүдийг газар ухаж, ханын толгойг далд ортол доош суулган барьсан нь хажуунаас буудсан суманд өртөхгүй, мөн алсаас харагдахгүй байдлыг харгалзсан явдал байв. Энэ удаагийн хамгаалалтын гол хүч нь 5 дугаар отрядын офицер, хилчид, хилийн тусгай группын гишүүд, Ховд аймаг дахь хэлтэс, цэргийн анги байсан бөгөөд тусгай үүргийн онгоц, шуурхай холбооны радио станц бэлэн байдалтай байсан юм.

Хамгаалалтын бэлтгэлийг хангаад 1944 оны 02 сарын 25-ны өглөө Оспаны шадар хүмүүсийх нь хамт уулзалтын байранд хүлээн авч, анхны уулзалт хэлэлцээр явагдаж маршал Х.Чойбалсан тэднийг зочлон дайлжээ. Маршал Х.Чойбалсанг өөрийн байрандаа хариу айлчлахыг Оспан урьснаар маргааш өдөр нь түүний

Г.А.Уэльст Намын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын Зил 101 машинаар үйлчилж, түүнийг Засгийн газрын Нүхтийн амралтын хоёр давхар дүнзэн байшин, дэргэд нь барьсан 12 ханатай Монгол гэрт байрлуулан хамгаалалт,

байрлаж байсан газарт нь очиж уулзан буцаж иржээ. Уулзалтын дүнд итгэлцлийн гэрээ¹ байгуулж, баруун хилийн түгшүүрт байдлыг түр боловч зогсоож чадсан байна. Хүнд нөхцөл байдлын дунд зохиогдсон энэ удаагийн хамгаалалт нь манай албаны түүхэнд онцгой байр эзлэн тэмдэглэх үйл явдал байлаа.

Дээд хэмжээний зочны төрийн тусгай хамгаалалт Америкийн Нэгдсэн Улсын Дэд Ерөнхийлөгч Г.А.Уэльс 1944 оны 07 сарын эхээр Хятад Улсад айлчлаад буцах 12 замдаа Улаанбаатарт бууж 2 хоног зочилсон нь тус улсад айлчилсан гадаад орны анхны дээд хэмжээний зочин байсан юм. Дэд Ерөнхийлөгчийн хамгаалагчаар Б.Болд, Гомбосүрэн нар нарыг ахлах дэслэгч цолтойгоор ажиллуулсан байна.

үйлчилгээг зохион байгуулжээ. АНУ-ын Дэд Ерөнхийлөгч өдрийн цагт гэрт, шөнө байшинд байрлан, Гандан хийд, Биокомбинат, Улсын их сургуульд зочилж, Бөмбөгөр ногоон театрт “Шарай голын гурван хаан” жүжиг үзжээ



Зураг.9 Америкйн Нэгдсэн Улсын Дэд Ерөнхийлөгч Г.А.Уэльс хамгаалалтын зураг

¹ Тусгаар тогтнол сэтгүүл, УБ 2018 он

АНУ-ын Дэд Ерөнхийлөгч Г.А.Уэльс нутаг буцахаар онгоц нь агаарт хөөрсөн боловч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан эргэн бууж, Гандан хийдээр зочилж дахин 1 хоноод явсан байна. Түүний явах замын дагуу болон очих газруудад нь байнга хүч нэмэгдүүлэн хамгаалалт зохиож, шөнийн цагт байрных нь гадна талд аюулаас хамгаалах газрын офицеруудыг ахлагчийн дүрэмт хувцас өмсгөн, автомат буугаар зэвсэглэн хамгаалуулж байжээ. 1948 онд гарсан Порт-Артурын хэрэг гэгчийн дараагаар далд хамгаалалтын группыг 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй машин, мотоцикл, унадаг дугуй, морь холбооны хэрэгслээр ханган ажиллуулж байжээ.

Дайны дараах жилүүдэд хамгаалалтын албадын ажлын заавар журмыг шинэчлэн боловсруулах, 1946 онд маршал Х.Чойбалсангийн өвлийн өргөө, 1951 онд зуны өргөө, Их тэнгэрийн аманд зочин төлөөлөгчийн байрууд баригдаж, хамгаалалтын лабораторийн багаж, хэрэгсэл, зочны машин зэрэг аж ахуйн үйлчилгээний талаар бэхжүүлэх арга хэмжээг дэс дараалалтай хэрэгжүүлжээ. 1954 онд зохиогдсон хамгаалалтын томоохон арга хэмжээнүүдийн нэг нь МАХН-ын 12 дугаар Их хурлын хамгаалалт байлаа.

Их хуралд урилгаар оролцсон ах, дүү намуудын төлөөлөгчдийн тэргүүн 11 хүнийг шадар хамгаалалтад авч, дэд хурандаа Цэрэнбалжир ахлагчтай шуурхай албаны хэсэг

байгуулж гадуур хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлсэн байна.

НАХЯ-ны сайдын 1969 оны 161 дүгээр тушаалаар тусгай үйлчилгээний хэлтсийг Гуравдугаар хэлтэст нэгтгэж газар эрхтэй болгож удирдлагуудыг шинээр томилжээ. Шинэ удирдлага хамгаалалт, үйлчилгээний ажлын удирдамж болох заавар, журмуудыг боловсруулан батлуулжээ.

Хамгаалалт зохион байгуулахад мина эрэгч, металл болон цагийн механизм илрүүлэгч, цацраг хэмжигч шөнийн дуран зэрэг багаж хэрэгслийг ашиглаж хамгаалалт зохиогдохоос өмнө үзлэг хийж хамгаалалтад авдаг болжээ. Улс орны хэмжээний арга хэмжээ, гадаадын хүндэт зочдын хамгаалалтыг яамны 1-р орлогч сайдын даргалсан штаб нэгдсэн төлөвлөгөө гарган аюулаас хамгаалах, цагдан сэргийлэх авто техникийн хөдөлгөөнийг зохицуулах албадын нийтдээ 1500-2000 хүнийг хамруулан зохион байгуулдаг байжээ.

Монгол Улсын Төрийн тусгай хамгаалалтын газар байгуулагдсан тухай:

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих хүрээнд тухайн үед мөрдөгдөж байсан эрх зүйн актууд хүчингүй болсон, тусгай хангамжийг үгүйсгэсэн үзэл бодолтой холбогдон НАХЯ-ны 3 дугаар газрыг цомхотгосон.

Үүнтэй уялдан төрийн хамгаалалттай холбоотой үүссэн асуудлуудыг шийдвэрлэх, үйл

ажиллагааны эрх зүйн үндсийг бий болгох зорилгоор 1995 онд Төрийн тусгай хамгаалалтын газрыг Тагнуулын ерөнхий газрын даргын дэргэдэх газрын статустайгаар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийг батлуулж байсан юм.

Түүнчлэн 2016 онд Монгол Улсад зохион байгуулагдсан Ази-Европын Дээд түвшний 11 дэх удаагийн уулзалтын аюулгүй байдлыг хангах бэлтгэл ажлыг аюулгүй байдлыг

хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бусад байгууллагатай хамтран хангаж, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэн, дээд түвшний уулзалтын аюулгүй байдлыг ханган ажилласан¹. АСЕМ-ын Дээд түвшний уулзалтад оролцох 55 улсын өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгч нарын аюулгүй байдлын хамгаалалт, үйлчилгээг иж бүрэн, найдвартай явуулж ирсэн.



Зураг.10 Ази-Европын Дээд түвшний 11 дэх удаагийн хамгаалалтын зураг

УИХ-аас 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсныг үндэслэн Засгийн газар 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр “Агентлаг байгуулах тухай” 218 дугаар тогтоол гаргаж, Төрийн тусгай хамгаалалтын газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх Засгийн газрын тохируулагч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Үй олноор

¹ Төрийн тусгай хамгаалалтын тухай, УБ 2018 он

хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтай тэмцэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль гэсэн нийт 12 хуульд болон УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан. Эдгээр эрх зүйн шинэчлэлийн үр дүнд ТТХГ нь Засгийн газрын тохируулагч агентлаг ¹ болж өөрчлөн байгуулагдах, үйл ажиллагаагаа тагнуулын байгууллагаас хараат бусаар, бие дааж явуулах эрх зүйн үндэс бүрдсэн байна.

ДҮГНЭЛТ

Төрийн Тусгай хамгаалалтын байгууллагын эрх зүйн үндэс, хамгаалалтыг хэрхэн зохион байгуулж ирсэн түүхэн уламжлалыг энэхүү өгүүлэлийг уншиж мэдсэнээр танин мэдэх болно. Төрийн Тусгай хамгаалалтын байгууллагын талаарх үндсэн ойлголт, Төрийн Тусгай хамгаалалтын үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн Тусгай хамгаалалтын тухай хууль зааснаар Хамгаалуулагчийн аюулгүй байдал болон , Төрийн Ордон, Засгийн газрын байруудын аюулгүй байдал хамгаалалтыг зохион байгуулж ажилладаг.

Ашигласан Эх сурвалж:

• Хүннү Тэргүүн дэвтэр, Лев Николаевич Гумилёв, УБ 2023.

• Монголын нууц товчоо, Ш.Чоймаа, УБ 2006 он.

• Чингис хааны цэргийн тухай өгүүлэл, Ж.Базарсүрэн УБ 2006 он.

• Төрийн хамгаалалтын түүхэн замнал I, УБ 2014 он.

• Төрийн хамгаалалтын түүхэн замнал II, УБ 2014 он.

• Монголын түүх: Хамаг Монгол улс, Ч.Далайхүү УБ 1996 он,

• Монгол цэргийн түүхийн товчоон (Тэргүүн дэвтэр), УБ 1996 он.

• Тусгаар тогтнол сэтгүүл, УБ 2018 он.

• Төрийн тусгай хамгаалалтын тухай, УБ 2018 он.

• Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн баг археологийн болон геофизикийн судалгаа 2013-2016 он.

• Тагнуулын операци тэргүүн дэвтэр, Л.Батдолгор, УБ 2015 он.

• Монгол хэлний товч тайлбар толь, Я.Цэвэл, УБ 1996 он.

• Монголын нууц товчоо, Д.Цэрэнсодном, УБ 2000 он

• <https://sspa.gov.mn/mn/>

Фото зураг:

• Монгол төрийн түүхийн музей.

• Монгол-Солонгосын хамтарсан “Мон-Сол” төслийн багийн судалгаа.

• Занабазарын дүрслэх урлагийн музей

¹ sspa.gov.mn